



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2016 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр

Улаанбаатар хот

Дугаар 200

БИЧИЛ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР БАТЛАХ ТУХАЙ

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 12.1, 12.2, 12.6, 23.1.11, Хөгжлийн банкны тухай хуулийн 7.1.1, 9.3-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. “Бичил бизнесийг дэмжих” хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.
2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 100.0 (нэг зуун) тэрбум төгрөгийн эх үүсвэрийг Хөгжлийн банкны татан төвлөрүүлсэн хөрөнгөөс шийдвэрлэхийг тус банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д, бичил бизнес эрхлэгчдэд 25.0 (хорин тав) хүртэл тэрбум төгрөгийн зээлийн батлан даалт зохих журмын дагуу гаргахыг Зээлийн батлан даалтын сангийн Удирдах зөвлөл (Н.Мандуул)-д тус тус зөвшөөрсүгэй.
3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зохион байгуулалтын зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх арга хэмжээ авч, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар ханган, хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөрийн сайд Г.Баярсайханд үүрэг болгосугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

Ч.САЙХАНБИЛЭГ

Хөдөлмөрийн сайд

Г.БАЯРСАЙХАН

БИЧИЛ БИЗНЕСИЙГ ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Улсын Их Хурлын 2015 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл”-ийн 1.2-т “ажлын байрыг хадгалах зарчим баримталж, ажилгүйдлийн түвшинг бууруулах”; 6.2-т “зээлийн батлан даалтын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх”; 18.2-т “залуучууд, мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, байнгын ажлын байраар хангахад чиглэсэн хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх”; Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр”-ийн 3.1-д “... ажил эрхлэлтийг дэмжих” зорилтыг хэрэгжүүлэхээр тус тус заасан.

Мөн “Төрөөс мөнгөний бодлогын талаар 2016 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай” Улсын Их Хурлын 2015 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 93 дугаар тогтоолоор “улсын төсөв, санхүү, мөнгөний бодлогыг эдийн засгийн бодит секторыг дэмжих, хувийн хэвшлийн идэвхжилийг сайжруулахад чиглүүлэх”-ийг Засгийн газарт даалгасан бөгөөд Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д “бичил, жижиг, дунд бизнесийг дэмжих замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын хүн амд эзлэх хувийг 80 хувьд хүргэх” зорилтыг хэрэгжүүлэхээр заасан.

1.2. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хөдөө аж ахуйг хөгжүүлэх олон улсын сангаас 5 аймгийн 50 суманд хэрэгжүүлсэн “Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжил” төслийн хүрээнд эмэгтэйчүүд зонхилсон 454 бизнесийн бүлгийн туршлагыг (зээлийн эргэн төлөлт 99 хувьтай, олон ажлын байр, нийгмийн хариуцлагатай аж ахуйн нэгжүүд шинээр бий болсон зэрэг) үндэсний хэмжээнд түгээж, хамтын хөдөлмөрийн албан бус хэлбэрийг санхүүгийн механизмаар дэмжиж, нийгмийн хариуцлага бүхий аж ахуйн нэгжийг төлөвшүүлэн эдийн засгийн өсөлтийг дэмжих нь зүйтэй байна.

1.3. Монгол Улсад 2015 оны IY улирлын байдлаар нийт ажиллагчдын 19.6 хувь нь хувиараа хөдөлмөр эрхэлж байгаа бөгөөд үйл ажиллагаа явуулж байгаа 65.7 мянган аж ахуйн нэгжийн 52 хувь нь “бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч” ангилалд багтаж байна.

Хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгжүүдэд бизнесээ тогтвортой эрхлэн ур чадвараа нэмэгдүүлж, ажлын байраа хадгалахад нь хөнгөлөлттэй зээл, зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байна.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, арга хэмжээ

2.1. Хөтөлбөрийн зорилго нь иргэдийн бүлгийг үүсгэн үндэсний хэмжээнд байгуулж, зээл, зээлийн батлан даалт, сургалт, зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх замаар ажлын байр бий болгон орлого нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг дэмжихэд оршино.

2.2. Хөтөлбөрийн зорилгын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

2.2.1. хөдөлмөрийн насны хүн амын тооноос хамаарч сум, хороо бүрт 8-10 хүнтэйгээр иргэдийн бүлэг (цаашид “бүлэг” гэх)-ийг үүсгэн байгуулах;

2.2.2. шинээр үүсгэн байгуулсан бүлэгт орон нутгийн онцлог бүхий бүтээгдэхүүн үйлдвэрлэх, үйлчилгээ эрхлэхэд нь зориулж жилийн 8 хүртэл хувийн хүүтэй зээлийг банкаар дамжуулан олгох;

Бүлгийн 1 гишүүнд ногдох зээлийн хэмжээ 2.0 сая хүртэл төгрөг байх бөгөөд үйл ажиллагаа нь тогтворжсон, өртөг шингэсэн үйлдвэрлэл эрхэлж байгаа буюу нэмүү өртгийн сүлжээнд хамрагдсан бүлгийн гишүүнд ногдох зээлийн хэмжээг 3 дахин нэмэгдүүлж болно. Зээлийн хугацаа тухайн бизнесийн онцлогоос хамаарч 12-36 сар байна.

2.2.3. бүлгийн авсан зээлийн 60 хүртэл хувийг Зээлийн батлан даалтын сангаас батлан даах;

2.2.4. бүлгийн ажил олоход хүндрэлтэй гишүүн тоног төхөөрөмж худалдан авсан тохиолдолд 2.0 сая хүртэл төгрөгийн зээлийн хүүгийн төлбөр болон бусад хөнгөлөлтийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлэх;

2.2.5. бүлгийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулах болон ажлын байрны түрээсийн хөнгөлөлт үзүүлэх үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлэх.

Гурав. Хөтөлбөрийн зохион байгуулалт

3.1. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хөтөлбөрийг нь Хөгжлийн банк, Зээлийн батлан даалтын сан, олон улсын байгууллага болон холбогдох яамтай хамтран хэрэгжүүлнэ.

3.2. Хөтөлбөрийн хүрээнд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.2.1. хөтөлбөрийг хэрэгжүүлэх ерөнхий нөхцөл бүхий гурван талт гэрээг Хөгжлийн банк болон Зээлийн батлан даалтын сантай байгуулж, аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллагаар дамжуулан хэрэгжилтийг зохион байгуулах;

3.2.2. хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд оролцох банкныг Хөгжлийн банктай хамтран сонгон шалгаруулах;

3.2.3. хөтөлбөрийн хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцогчдыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, биелэлтэд нь хяналт тавих, холбогдох байгууллагад тайлагнах.

3.3. Хөтөлбөрийн хүрээнд Хөгжлийн банк дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1. хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан хуваарийн дагуу зээлийн эх үүсвэрийг оролцогч банкинд шилжүүлэх;

3.3.2. оролцогч банкинд олгох зээлийн дээд хэмжээ, Хөгжлийн банкнаас тогтоосон хүү болон оролцогч банкны хүүгийн маржины дээд хязгаарыг тогтоож зарлах;

3.3.3. оролцогч банкнаас ирүүлсэн зээлийн хүсэлт, зээлийн хорооны хурлын шийдвэр, өмнө нь авсан зээлийг ашигласан тайлан зэрэг баримтыг нь үндэслэн тус банкинд зээл олгох.

3.4. Хөтөлбөрийн хүрээнд Зээлийн батлан даалтын сан дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.4.1. бичил бизнест зориулсан зээлийн батлан даалтын шинэ бүтээгдэхүүн бий болгож хэрэгжүүлэх;

3.4.2. эрх бүхий этгээдийн гаргасан зээл олгох шийдвэрийг үндэслэн бичил бизнес эрхлэгчид зээлийн батлан даалтын үйлчилгээ үзүүлэх.

3.5. Хөтөлбөрийн хүрээнд аймаг, дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн байгууллага дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.5.1. хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас сонгон шалгаруулсан төрийн бус байгууллага болон сум, хорооны хөдөлмөр эрхлэлтийн ажилтнаар дамжуулан бичил бизнес эрхлэгчдэд сургалт, зөвлөгөө, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх;

3.5.2. хөтөлбөрт хамрагдах иргэдийн хүсэлтийг шийдвэрлэн хэрэгжилтийг зохион байгуулах;

3.5.3. хөтөлбөрийн 2.2.4, 2.2.5-д заасан арга хэмжээг зохион байгуулах;

3.5.4. зээл, зээлийн батлан даалтын үйлчилгээ авах хүсэлтийг Хөгжлийн банкинд уламжилж шийдвэрлүүлэх.

3.6. Хөтөлбөрийн хүрээнд оролцогч банк дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.6.1. бүлгээс ирүүлсэн хүсэлт болон энэ хөтөлбөрийн 3.2.1-д заасан гэрээний дагуу зээл олгох;

3.6.2. зээлийг зориулалтын дагуу зарцуулж байгаа байдалд хяналт тавьж ажиллах;

3.6.3. зээлийн санхүүжилтын тайланг сар бүр гарган хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хөгжлийн банкинд тус тус хүргүүлэх.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, санхүүжилт

4.1. Хөтөлбөрийг 2016-2018 онд хэрэгжүүлнэ.

4.2. Хөтөлбөрийг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

4.2.1. Хөгжлийн банкны зээлийн хөрөнгө;

4.2.2. Зээлийн батлан даалтын сангийн хөрөнгө;

4.2.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгө;

4.2.4. гадаадын зээл, тусламжийн хөрөнгө;

4.2.5. бүлгийн өөрийн хөрөнгө.

Тав. Хүрэх үр дүн

5.1. Хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүнд хүрнэ:

5.1.1. хөтөлбөрийн хүрээнд аймгийн төвийн суманд 40 хүртэл, 5000-аас дээш хүн амтай суманд 20 хүртэл, 5000 хүртэл хүн амтай суманд 10 хүртэл, нийслэлийн хороо бүрт 15 хүртэл буюу үндэсний хэмжээнд нийт 6000 бүлэг байгуулагдаж, тэдгээрийн 50-иас доошгүй хувийн үйл ажиллагаа тогтворжино;

5.1.2. бүлэг бүрт гишүүдийн мөнгөн хуримтлалд суурилсан санхүүгийн дундын сан байгуулагдаж, орон нутаг дахь хөрөнгийн эргэлт сайжирна;

5.1.3. орон нутгийн онцлог бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээ нэмэгдэнэ;

5.1.4. сум, хороо бүрт 500-гаас доошгүй хүний орлого нэмэгдэж, нийт 60 мянган ажлын байр шинээр бий болно.

---o0o---